

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад “Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

- 7.1.1.ард түмэнд үйлчлэх;
- 7.1.2.мэргэшсэн, тогтвортой байх;
- 7.1.3.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;
- 7.1.4.Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;
- 7.1.5.төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;
- 7.1.6.ил тод байх;
- 7.1.7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 7.1.8.захирах, захирагдах ёсыг баримтлах” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөрийн зорилго 2-т “Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ” гэж заасан.

2020 оны байдлаар Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн хөрөнгө 125,306,840,000.00 /Зуун хорин таван тэрбум гурван зуун зургаан сая/ төгрөг орчим байна. Тодруулбал, 50 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө орлоготой Засгийн газрын гишүүн нэг, 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө орлоготой Засгийн газрын гишүүн дөрөв, 1-10 тэрбум төгрөгийн хөрөнгө орлоготой Засгийн газрын гишүүн 13, 1 тэрбум хүртэлх төгрөгийн хөрөнгө, орлоготой гурав байна.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуульд хувийн өмчийн бүх хэлбэрийг зөвшөөрсөн, иргэд шударгаар хөдлөх, үл хөдлөх хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх эрхтэй ч Засгийн газрын гишүүд эдгээр хөрөнгө орлогыг шударгаар олж авсан эсэх, нийтэд ил мэдээлсэн эдгээр хөрөнгө орлогодоо хуулиар тогтоосон татвар төлсөн эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл Засгийн газрын гишүүд хөрөнгө орлогын мэдүүлэгтээ дурдсан хөрөнгө орлогыг шударгаар олж авсан эсэх нь олон нийтэд тодорхой бус байна.

Үүнээс гадна Transparency International байгууллагаас гаргасан 2025 оны “Авлигын төсөөллийн индекс (CPI)”-ээр Монгол Улс 31 оноо авч, 182 улсаас 124-р байрт орсон нь 2024 онтой харьцуулахад 2 оноо 10 байраар ухарсан үзүүлэлт болж байна.

АТГ-ын үйл ажиллагааны тайланд дурдсанаар 2025 онд авлигын улмаас 674.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх онтой харьцуулахад 61.7%-иар өссөн. Мөн АТГ 1322 гомдол хүлээн авч, 367 хэргийг шүүхэд шилжүүлсэн ч нөхөн төлөгдсөн хохирлын хэмжээ нийт хохирлын ердөө 37% орчим буюу ойролцоогоор 247.8 тэрбум төгрөг, үлдсэн 63% буюу 426.9 тэрбум төгрөг нөхөн төлөгдөөгүй байна.

Эдгээр тоон үзүүлэлтүүд АТГ-ын бие даасан байдал сул байгааг илтгэж, улс төрийн нөлөөлөл, томилгооны ил тод бус байдал нь авлигатай тэмцэх үр дүнгийн гол саад болж байгааг харуулж байна.

Дүгнэвэл, Авлигатай тэмцэх газар (АТГ) нь төрийн бие даасан, хараат бус байгууллага байх ёстой атал одоогийн хуулийн зохицуулалтаар АТГ-ын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилдог нь улстөрийн нөлөөлөл ихтэй байгааг олон улсын судалгаа болон дотоодын статистик, тоо баримт харуулж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасны дагуу Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийг өөрчлөн найруулж, дараах гол зохицуулалтыг тусгана. Үүнд:

1. АТГ-ын даргыг Улсын Их Хурал ил тод, өрсөлдөөнтэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр 5 нэр дэвшигч дээр нууц санал хураалт явуулж, олонхийн саналаар 6 жилийн хугацаагаар томилох
2. Нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах ажлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо зохион байгуулах
3. Нэр дэвшигчдийг ил тод зарлаж, томилгооны сонсгол хийж, олон нийтэд мэдээлэх
4. Нэр дэвшигч нь хамгийн багадаа 35 нас хүрсэн, авлига, албан тушаалын хэрэгт холбогдож байгаагүй, ёс зүй, мэргэжлийн өндөр шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байх
5. АТГ-ын дэд даргыг АТГ-ын даргын санал болгосноор УИХ томилох

Гурав. Хуулийн төслийн нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар

Эрх зүйн үр дагавар: АТГ-ын хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж, Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлд заасан төрийн байгууллагын бие даасан байдлыг хангаж, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцэд нийцүүлж, томилгооны ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

Нийгмийн үр дагавар: Нийгмийн судалгаагаар иргэдийн 60-70% нь авлигатай тэмцэх байгууллагын ажилд сэтгэл хангалуун бус байгааг харгалзан АТГ-ын үйл ажиллагааг сайжруулж, шударга ёсыг бэхжүүлнэ.

Эдийн засгийн үр дагавар: Авлига буурсанаар төрийн болон хувийн өмч, хөрөнгө илүү үр ашигтай зарцуулагдаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Үүнд нэмэлт төсөв шаардагдахгүй.

Болзошгүй эрсдэл ба шийдэл: Томилгоо удаашрах эрсдэлтэй бөгөөд уг эрсдэлийг хугацаатай журам батлан шийдвэрлэх боломжтой. Улстөрийн саатаал үүсгэхгүй байхын тулд сонгон шалгаруулалтын журмыг тодорхой болгох нь зүйтэй.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжтой уялдсан байдал

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

Тав. Дүгнэлт

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцоог олон улсын шилдэг туршлагад нийцүүлж, АТГ-ыг улстөрийн нөлөөлөлөөс ангид, ил тод, хариуцлагатай, үр дүнтэй байгууллага болгоход чиглэгдэнэ. Төсөл батлагдсанаар Монгол Улсын “Авлигын төсөөллийн индекс”-ийг дээшлүүлэх, ард иргэдийн шударга ёсны итгэлийг сэргээхэд чухал алхам болно.

ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ